ЭШЛЭЛ 1

Миний хувьд орон гэр гэж хэлэхийг хүсдэг зүйл болохоороо тав тух, тайван мэдрэмж, хэн намайг юу гээд бодчих бол гэсэн айдас байхгүй, яг өөрөөрөө байдаг тийм орчныг хэлнэ дээ

ЭШЛЭЛ 2

Заа, надад гэр оронд тооцдог 3 газар байна. Төрсөн гэр, ээж аав дүү нартайгаа амьдардаг, цуглаан, итгэгч ах эгч нартайгаа нөхөрлөдөг. Тэгээд ЛГБТ төв. ЛГБТ төв дээр болохоороо би яг өөрийнхөө транс байдлын талаар онцгойлж бодож ингэж, зөрчил мэдрэхгүйгээр, юу ч бодохгүйгээр гэх юм уу, аймаар тайван байгаад л, найзуудтайгаа гоё инээлдэж ханиалдаад л, тэгж авсан тийм эрч хүчээрээ гэх юм уу бусад газар орчинд өөрөөрөө байх, тэгээд бусдын ойлгохгүй байгаа байдлыг давах эрч хүчтэй болдог.

ЭШЛЭЛ 3

Яагаад гэр оронд тооцоод, гэр орон гэдэг мэдрэмж төрж байна вэ гэхээр хамгийн түрүүнд тайван байдаг. Яагаад гэвэл, дотроо зөрчил мэдрэхгүй, өөрийгөө би энгийн хүн шүү дээ гэсэн мэдрэмжийг эндээс аваад, бусадтайгаа харьяалагдах мэдрэмж авдаг. Тэгээд би чинь энэчээ яваад тэгээд ЛГБТ төвтэйгээ ойрхон байгаад сайн дурын ажил хийгээд 4 жил болж байна уу 5 жил болж байна уу 5 жил болж байгаа юм байна. Тэгэхээр одоо ингээд сүүл рүүгээ бүүр нэг, нэг хэсэг болчихсон, одоо ингээд удаан ирэхгүй байхаар жоохон санаж манадаг.